



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл  
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөх нуур трейд ХХК-ийн “Капелла” зочид буудлын 17/267, Эс энд пи эл ХХК-ийн “Американ” зочид буудлын 18/34, Гоулд констракшн ХХК-ийн “Гоулд” зочид буудлын 18/56, Ноён капитал ХХК-ийн “Амар” зочид буудлын 17/265, Их сүлд групп ХХК-ийн “Амгалан” зочид буудлын 18/81, Их дэлгэц трейд ХХК-ийн “Сөүл” зочид буудлын 18/25, Туушин зочид буудал ХХК-ийн “Бэст вэстэрн премьер” зочид буудлын 18/31, Өлзий бэл ХХК-ийн “Грейт импайр” зочид буудлын 18/43, Өлзий бэл ХХК-ийн “Их улс” зочид буудлын 18/42, Ашид суврага ХХК-ийн “Ашид эрдэнэ” зочид буудлын 18/54, Кровн баг ХХК-ийн “Хотол” дэн буудлын 18/23 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

Баталсан  
Хүндэтгэсэн  
Хүндэтгэсэн

1150500097




4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.


6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА *D. Balto* Д.БАТСҮХ





Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 02  
сарын 22 өдрийн А/15 дүгээр  
тушаалын 2 дугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.02.22

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Кровн баг ХХК	5193052	Хотол	СХД-ийн, 13-р хорооны 1-р хорооллын 196-р байр
2	Ай эм ай трэйвел ХХК	6275184	Анарс	БГД-ийн, 3-р хорооны 36-17

-ooOoo-